


## ТЕРМОДИНАМИК АЖИЛ

$S$  талбайтай булүүрээр нягт тагласан саванд байгаа  $m$  масстай,  $\mu$  моль масстай идеал хийг тогтмол  $F$  хүчээр шахахад бүлүүр  $\Delta h$  зайд шилжсэн гэе.




Хийг шахах үед хийсэн ажлыг ольё.

$$A = F\Delta h, P = \frac{F}{S} \Rightarrow F = PS$$

$A = PS\Delta h$  буюу

$A = P\Delta V$ -Термодинамик ажил

Энд  $\Delta V = V_2 - V_1$ -ээлэхүүний өөрчлөлт болно.



Жишээ:  $0^{\circ}\text{C}$  температуртай  $15\text{m}^3$  эзлэхүүн бүхий агаар  $6 \cdot 10^4$  Па даралттай байв. Агаарын температурыг  $20^{\circ}\text{C}$ -ээр нэмэгдүүлж изобараар тэлүүлэхэд оруулахад хэдий хэмжээний ажил хийгдэх бэ?

**БОДОЛТ:** Хий изобар процессоор тэлэхэд хийгдэх ажил нь  $A = P\Delta V$ .

Энд  $V_1, V_2$ -хийн эхний ба эцсийн эзлэхүүн.

Изобар процесст даралт тогтмол учраас  $P_1 = P_2 = P$ . Гей-Люссакийн хуулийг бичвэл:  $\frac{V_2}{V_1} = \frac{T_2}{T_1}$ .

Эндээс эцсийн эзлэхүүн  $V_2 = \frac{T_2 V_1}{T_1}$

$T_1 = 273K$ ,  $T_2 = 293K$  тул өгөгдлүүдийг томьёонд орлуулбал:

$$V_2 = \frac{293K \cdot 15m^3}{273K} = 16.1m^3 \text{ ба}$$

хийгдэх ажил нь:  $A = 6 \cdot 10^4(16.1m^3 - 15m^3) = 6.6 \cdot 10^4 \text{Ж} \text{ болно.}$

Жишээ: 84г азотыг 470K температуртай болтол нь изобараар халааж, түүний эзлэхүүнийг нэмэгдүүлэхэд 2.493Ж ажил хийгдэв. Хийн анхны температурыг ол.

**БОДОЛТ:** Хий изобар процессд тэлэхэд хийгдэх ажил нь  $A = P\Delta V$ . Дурын масс бүхий идеал хийн хувьд Клайперон-Менделеевийн тэгшитгэлийг бичвэл:

$$P\Delta V = \frac{m}{\mu} R\Delta T$$

Үүнийг термодинамик ажлын томьёонд орлуулбал:

$$A = \frac{m}{\mu} R\Delta T \text{ болно. Эндээс } \Delta T = \frac{A\mu}{mR} = 100K$$

$$\Delta T = T_2 - T_1; \text{ Эндээс } T_1 = 370K \text{ болно.}$$

Жишээ: Цилиндр саванд 20кг масстай нүүрсхүчлийн хий оршино. Хийг халаахад температур нь 88K-ээр нэмэгдсэн бол хийн гүйцэтгэсэн ажлыг ол.

**БОДОЛТ:** Цилиндр саван доторх хий тогтмол даралтын дор тэлнэ. Энэ үед хийн гүйцэтгэсэн ажил  $A = P\Delta V$ .

Дурын масс бүхий идеал хийн хувьд Клайперон-Менделеевийн тэгшитгэлийг бичвэл:

$$P\Delta V = \frac{m}{\mu} R\Delta T$$


Үүнийг термодинамик ажлын томьёонд орлуулбал:

$$A = \frac{m}{\mu} R\Delta T$$


болно. Мэдэгдэж буй өгөгдлүүдийг дээрх томьёонд орлуулбал:  $A = 0.3M\text{Ж}$  болно.

## ДАСГАЛ БОДЛОГО


1.  $3 \cdot 10^5$  Па даралтанд орших 4.6 л эзлэхүүнтэй хий изобараар тэлж 3.5 л эзлэхүүнтэй болсон бол ямар ажил гүйцэтгэх вэ?
2. Зурагт 0.5 моль устэрөгчийн хийд явагдсан цикл процесийг диаграммаар үзүүлэв.




- раммаар үзүүлэв.
- Устэрөгч хийн массыг
  - Аль төлөвт температур хамгийн бага байхыг
  - "3"төлөв дэх хийн дотоод энергийг
  - "1"циклд хийсэн ажлыг тус тус ол.
  3. Зурагт 1 атомт идеал хийн даралт эзлэхүүнээс хамаарах хамаарлын графикийг үзүүлжээ. Идеал хий "1"төлөвөөс "2"төлөвт шилжихэд ямар хэмжээний ажил хийгдсэн бэ? (график ашиглаарай)



4. Зурагт хийн молекулуудын хөдөлгөөний чиглэл болон байрлалыг үзүүлэв.



- Молекулын хөдөлгөөнийг тодорхойлон бич.
  - Молекулууд савны хананд хэрхэн даралт учруулахыг тайлбарла.
5. Зурагт мөсний хайлахын хувийн дулааныг хэмжихэд ашигласан баражийг харуулав. Баражийг хэрхэн ашиглахаа тодорхойл. Чамд хугацаа хэмжигч хэрэгтэй юу?



Туршилтаар  $0^{\circ}\text{C}$  температурт байгаа  $120\text{г}$  мөсийг хайлуулсан. Мөсний хайлахын хувийн дулаан  $340 \frac{\text{Ж}}{\text{Г}}$ . Халаагуураас авсан бүх дулаан мөсийг хайлуулахад шаардагдах бол  $60\text{Вт}$  чадалтай халаагуурыг ажиллуулахад шаардагдах хугацааг ол.

6.  $200\text{kPa}$  даралттай хий изобараар тэлэхэд  $500\text{Ж}$  ажил хийгдэв. Хий тэлсний дараах эзлэхүүн  $3.5 \cdot 10^{-3} \text{m}^3$  бол тэлэхээс өмнөх эзлэхүүнийг ол.
7.  $50\text{г}$  масстай устэрөгч изобараар тэлж эзэлхүүн нь гурав дахин ихсэв. Хийн анхны температур  $320K$  бол хийн эцсийн температур болон тэлэхдээ гүйцэтгэсэн ажлыг тус тус ол.
8. Саванд  $-20^{\circ}\text{C}$  температуртай  $3 \text{ кг}$  мөс байв. Савтай мөсийг  $2 \text{ кВт}$  чадалтай зуухан дээр тавив. Мөсний хувийн дулаан багтаамж  $2100 \text{ Ж/(кг · град)}$ , мөсний хайлахын хувийн дулаан  $340 \text{ кЖ/кг}$ , усны хувийн дулаан багтаамж  $4200 \text{ Ж/(кг · град)}$ , мөсний хайлах температур  $0^{\circ}\text{C}$ . Савны дулаан багтаамжийг тооцохгүй.
  - а Савны температурыг ол.
  - б Мөсийг хайлуулахад хичнээн дулаан хэрэгтэй вэ?
  - с Зуухыг хэдэн секунд ажиллуулахад  $1.8 \text{ кг}$  мөс хайлаагүй үлдэх вэ?
9. Зурагт 2 атомт идеал хийн даралт эзэлхүүний хамаарлын графикийг үзүүлэв. Хийн нийт гүйцэтгэсэн ажлыг олно уу. 1-р төлөвт хийн даралт  $2P_0$  байсан

